




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3097 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
8.9%



НИЙТ ХАДГАЛАМЖ
18.3 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
33.3 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
1034 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
10%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: **6%**,
Инфляци: 2022 онд: **8.2%**,
Урсгал тэнцэл: 2022 онд: **-10.2%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: **7.5%**
Инфляци: 2021 онд: **7.3%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: **-8.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3ax1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 6-р сарын байдлаар 844 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 59.4 хувиар өссөн бол, зарлага 9.3 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 844 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 21.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 14.03 төгрөгөөр өсчээ.

Зургаадугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 275 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 14.03 төгрөгөөр өсч 3124.25 төгрөг болов. 6-р сард гадаад валютын нөөц 3 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас -0.93 оны эхнээс 29.06 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 34.54 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцын түвшин 16.1%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 6-р сарын байдлаар өмнөх сараас 1.5 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар, оны эхнээс 9.5 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 19.5 хувь (мах, махан бүтээгдэхүүн 2.4 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 29.1 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 14.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 27.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 1360 сая.ам долларын ашигтай гарав.

2022 оны зургаадугаар сард нийт барааны эргэлт 9256 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 25.5 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 29.1 хувь, импорт өмнөх оны мөн үеэс 21 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 1360 сая ам.долларын ашигтай гарав.



6-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.1212.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 6-р сард өмнөх сараас 0.9 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 22.5 хувиар тус тус өсч 23.4 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 2102 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 7.5 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 12.3 хувиар буурсан байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.95% байна.

САРЫН ОНЦЛОХ

БОДЛОГЫН ХҮҮГ 1 НЭГЖ ХУВИАР НЭМЖ, 10 ХУВЬД ХҮРГЭВ

- Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны энэ сарын 20, 22-ны ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмж, 10 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Гадаад хүчин зүйлс, геополитикийн сөрөг нөлөө үргэлжилж байгаагаас инфляцын хүлээлт нэмэгдэх, хилийн хязгаарлалтаас шалтгаалан нүүрсний экспорт буурч, гадаад зах зээл дээрх үнийн өсөлттэй холбоотой импорт нэмэгдэж, улмаар төлбөрийн тэнцлийн алдагдал өсөж байна.

ГАДААД ХУДАЛДАА

- Энэ оны эхний 6 сарын байдлаар манай улсын алтны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.3 дахин, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 22 хувиар тус тус өсжээ. Харин төмрийн хүдрийн биет хэмжээ 57 хувиар, нүүрсний экспортын биет хэмжээ 16 хувиар буурчээ. Манай улсын гадаад худалдааны тэнцэл 2022 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 тэрбум ам.долларын ашигтай гарчээ.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 6-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 6-р сар 2022 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn